

ЗУРАГ ТӨСАЛ, УГСРАЛТЫН "АРЛЫН АМ" ХХК
ЗТ37 - 149/22, Монгол улс Дархан - Уул аймаг, Дархан сум

Зургийн шифр: 17/03/2026

30-Р ЦЭЦЭРЛЭГИЙН ГАДНА ТАЛБАЙГ ТОХИЖИЛТ, НОГООН БАЙГУУЛАМЖИЙН АЖИЛ

(Хэмжилтийн зураг)

Захирал: / Э. Соёл - Эрдэнэ /

ДАРХАН ХОТ
2026 он

Тайлбар бичиг

Цэцэрлэгийн гадна талбайд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, хүүхдийн эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэх, тоосжилтыг бууруулах, бичил уур амьсгалыг сайжруулах зорилгоор мод, зүлэгжүүлэлтийн ажлын зураг төслийг боловсруулав.

Ерөнхий шийдэл

Талбайн зохион байгуулалтыг хүүхдийн хөдөлгөөний урсгал, тоглоомын талбайн байршилтай уялдуулан төлөвлөж, ногоон байгууламжийг хамгаалалтын болон гоёлын зориулалтаар бүсчилж байрлуулсан. Мод, бут сөөгийг салхи, нарны тусгал, хөрсний нөхцөлд нийцүүлэн сонгосон.

Зүлэгжүүлэлтийн хийц, үе давхарга

Зүлэгжүүлэлтийг дараах үе давхаргын дагуу гүйцэтгэнэ.

Үүнд:

Суурийн хөрсийг 150–200 мм гүн ухаж, тэгшилж нягтруулна

5–10 см зузаантай хайрган дэвсгэр үе хийж ус нэвчилтийг сайжруулна

10–15 см үржил шимт хар шороон үе дэвсэж тэгшилнэ

Зүлэгний үрийг 30–50 г/м² нормоор жигд цацна

Үрийг 1–2 см зузаантай шороогоор хучиж, булж нягтруулна

Анхны усалгааг жигд хийж, чийгийг тогтмол хадгална

Мод, бут сөөг тарих технологи

Мод тарих нүхийг 600×600×600 мм (эсвэл модны төрлөөс хамаарч) хэмжээтэй ухна

Ёроолд нь 10–15 см хайрган дренаж үе хийнэ


Үржил шимт хөрсийг бордоотой хольж буцаан дүүргэнэ

Суулгацыг босоо байрлалд байрлуулж, үндсийг гэмтээлгүйгээр булна

Усалгааг 20–30 л/ширхэг нормоор хийнэ

Модыг 2–3 тулгуур модоор бэхэлж уналтаас хамгаална

Бут сөөгийг 300–400 мм гүн нүхэнд суулгаж, хоорондын зайг 0.5–1.5 м байхаар төлөвлөнө.



АРЛЫН АМ ХХК

Дархан - Уул аймаг, Дархан сум 30-р Цэцэрлэг					
	Овог нэр	Г. үсэг	Огноо	Гадна талбайн тохижилт, ногоон байгууламжийн ажил	
Инженер	Х. Отгонсүрэн			Масштаб:	
Гүйцэтгэсэн	Х. Отгонсүрэн			Хуудас	Бүх. ху
				1	1
				ЕГ шифр:	
				ТГ шифр:	
				17/03/2026	

төслийн танилцуулга

2026.03.17

Төслийн нэр:	“Хүүхдийн хөгжлийн төлөө хамтдаа”
Төслийн бүтэц	Цэцэрлэгийн гадна талбайг, зүлэгжүүлэх, моджуулах
Хөтөлбөр хэрэгжүүлэгчийн байршил	Дархан сум 4-р баг 22-р хороолол 30 дугаар цэцэрлэг /хуучин прокурорын байр/
Төсөл санаачлагч	30-р цэцэрлэгийн багш, ажилчид хамт олон
Төслийн үр шим хүртэгч	30-р цэцэрлэгийн хүүхдүүд болон 4-р багийн иргэд хүүхдүүд
Төслийн санхүүжүүлэгч	Дархан –Уул аймгийн ЗДТГ, “Ногоон Дархан-2032” хөтөлбөр
Төслийн нийт төсөв	12.195.000 төгрөг
Төсөл хэрэгжүүлэх хугацаа	2026 оны 1-р улиралд

ЦЭЦЭРЛЭГИЙН ТАНИЛЦУУЛГА

1. Цэцэрлэгийн дугаар: 30 дугаар цэцэрлэг
2. Цэцэрлэгийн байршил: Дархан сум 4-р багийн нутаг дэвсгэр
3. Хамран сургах тойрог: Дархан сум 4, 5-р багийн нэмэлтээр
гэр хорооллын Малчин багийн хүүхдүүд
4. Хүмүүжүүлж буй хүүхдийн тоо: 265 хүүхэд
5. Багш ажиллагсдын тоо : 32 багш, ажилтан

Дархан сумын 30-р цэцэрлэг нь анх 1982 оны 4-р сарын 20-нд байгуулагдан “Орос” цэцэрлэг нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж байгаад 1992 онд татан буугдсан түүхтэй. Олон жил ашиглагдаагүй гадны нөлөөллөөр тоногдсон барилгыг Дархан уул аймгийн Засаг захиргаа ОХУ-ын Хилийн чанад дахь өмчийг удирдах үйлдвэрийн газартай гэрээ байгуулан түрээслэн авч 2020 онд их засвар хийгдэн ашиглалтад орж 2020 оны 09 дүгээр сарын 31-нд үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн бөгөөд одоогийн байдлаар 265 хүүхэд хамрагдан суралцаж байна.

БИДНИЙ УРИА:

“Хайраар үлгэрлэе, Хамтдаа хөгжье”

АЛСЫН ХАРАА

Хүүхэд бүр аз жаргалтай суралцан хүмүүжин хөгждөг МАНЛАЙЛАГЧ ЦЭЦЭРЛЭГ болно.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Үлгэрийн олон талт арга зүйгээр хүүхдэд зөв үнэт зүйлийг төлөвшүүлнэ.

Төслийн тодорхойлолт:

Цэцэрлэгийн гадна тоглоомын талбай нь хүүхдийн хөгжлийг дэмжсэн тоглоом хэрэглэгдэхүүн, ногоон байгууламж дутмаг байгаа нь СӨБ-ын байгууллагын орчны стандарт шаардлагыг хангахгүй байгаа тул энэхүү төслийг хэрэгжүүлэх шаардлагатай байна. Төсөл хэрэгжсэнээр хүүхдийн сургалтын болон тоглох орчин бүрдэх бөгөөд ялангуяа хүүхдийг тоглонгоо ногоон эко орчноос суралцах, мод ургамлын нэр төрлийг таних, мэдэх, гадаа талбайд чөлөөтэй тоглох, идэвхтэй хөдөлгөөнийг дэмжих, хүүхэд гүйх, авирах, мөлхөх үсрэх зэрэг үндсэн хөдөлгөөний чадварыг эзэмшихэд чухал нөлөө үзүүлэх эрүүл аюулгүй орчин бүрдэнэ.

Төслийн үндэслэл:

Цэцэрлэгийн гадна тоглоомын талбай нь хүүхдийн хөгжил, сонирхол, хэрэгцээг дэмжсэн тоглоом хэрэглэгдэхүүн, ногоон байгууламж дутмаг байгаа тул энэхүү орчинг сайжруулах бололцоог хангахыг эрмэлзэж байна.

Гадна тоглоомын талбай тохижуулснаар хүүхдийн идэвхтэй хөдөлгөөнийг дэмжсэн суурин болон аюулгүй байдлыг хангасан тоглоомтой болох, нар, ус, агаараар чийрэгжүүлэх орчинг бүрдүүлэн ногоон эко орчин бүрдүүлэх, хүүхдийн аюулгүй байдлыг хангасан талбайг бий болгох.






Төслийн зорилго:

Бага насны хүүхдийн нас сэтгэхүйн хөгжлийн онцлогт тохирсон тэднийг ногоон эко орчинд суралцах мод, ургамлын нэр төрлийг таниулах, хайрлах, хамгаалах, арчилж ургуулахад сургах, бие бялдар хөдөлгөөний хөгжлийн хэрэгцээг хангах, идэвхтэй хөдөлгөөнийг дэмжсэн зориулалт бүхий тоглоом хэрэглэгдэхүүнээр тохижуулах, нар ус агаараар чийрэгжүүлэх тоглоомоор эрүүл аюулгүй орчныг бүрдүүлж ажиллах зорилготой.






Гарах үр дүн:

Цэцэрлэгийн гадна талбайд бага насны хүүхдийн тоглож наадах, агаар салхинд бие бялдын хөдөлгөөнийг дэмжих чийрэгжих аюулгүй, эко орчин бүрдэнэ.

ТӨСЛИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ТООЦОО(1200м²)

№	Материалын нэр төрөл	Үзүүлэлт төрөл зүйл	Хэмжих Нэгж	Тоо, хэмжээ	Нэгж үнэ, төг	Нийт үнэ төгрөг	Шаардлагатай материалын зураг	Эх сурвалж
1	Үр /олон наст/	40% Овсяница красная красная (Festuca rubra rubra) 5% Овсяница красная изменённая (Festuca rubra commutata) 55% Райграс пастбищный (Lolium perenne)	Кг	90	35.000	3.150.000		“Экстра ургамал төв” https://www.facebook.com/URGAMALTUV
2	Хар шороон хөрс	Уулын хар шороо	м.куб	15	100.000	1.300.000		Хувь хүн
3	Элс	Торгон элс	м.куб	10	66.000	660.000		Хувь хүн
4	Гацуур /бортоготой/	2-3 настай 1.0-1.5м өндөр	ш	10	350.000	3.500.000		https://www.facebook.com/photo/?fbid=1162893651997778&set=pcb.1162900331997110
5	Бүйлс	3-5 настай 0.6-1.0м өндөр	ш	20	35.000	700.000		https://www.facebook.com/photo/?fbid=1162893651997778&set=pcb.1162900331997110

								16290033199711 <u>0</u>
6	Хөх далайн хальс /бортоготой/	3-5 настай Нутагшсан сорт	ш	6	30.000	180.000		УГТ хүрээлэн
7	Үхрийн нүд /ТОМ ЖИМСТ/	0 сортын 2-3 настай	ш	20	10.000	200.000		УГТ хүрээлэн
8	Насос	1.5WZB-40, 220вт	ш	1	240.000	240.000		https://bigcenter.mn/product/1796
9	Усалгааны сав	Орос усны сав нь - 45°C, +65°C хэмд хөлдөхгүй, урвалд орохгүй, эрүүл ахуйн шаардлага хангасан	тонн	1	550.000	550.000		http://zar.bbe.mn/advertisement=289cca39-985a-4708-8dad-df258f6c2db9

10	Гуравлагч	Ø20X16X20	ш	25	10000	250.000		https://bigcenter.mn/product/1022
11	Холбогч	25, 32мм хэмжээтэй	ш	20	1000	20.000		https://bigcenter.mn/product/1022
12	Хаалт	25,32мм-ийн хэмжээтэй PVC хоолойны хаалт	ш	30	1500	45.000		https://www.facebook.com/photo/?fbid=221122920439512&set=pcb.221124543772683
13	Насотик	2 талт бороожуулагч 360 Градус эргэнэ, хооронд нь холбох боломжтой.зүлэг, мод, бут, ногоо услах зориулалттай бороожуулагч 6-10 метр хүртэл цацрана.	ш	30	25.000	750.000		https://www.facebook.com/photo/?fbid=1142120494385743&set=pcb.1142120527719073
14	PVC хоолой	32мм	м	100	3500	350.000		https://bigcenter.mn/product/1022
15	PVC хоолой	25мм	м	100	3000	300.000		
16	Нийт дүн /төгрөг/					12.195.000		

Төсөл бичсэн 30 дугаар цэцэрлэгийн Эрхлэгч

Х. Отгонтуяа

Дархан сумын 30 дугаар цэцэрлэгийн зүлэгжүүлэх талбайн зураг



Зүлэгжүүлэх талбай 1200m^2 , ашиглагдсан талбай нь 192m^2

